

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	2
Төслийн товч танилцуулга	2
1.1. Төслийн товч тодорхойлолт	2
1.2. 2023 оны уулын ажлын хэмжээ, ажиллах горим.....	5
1.3. Үйлдвэрлэлийн нөөц.....	5
1.4. Хүдрийн хаягдал, бохирдол	5
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	6
2.1. 6	
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, биелэлт.....	7
3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	8
3.1. Агаар орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажил:.....	8
3.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажил.....	8
3.3. Хөрс, ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалахад хийгдсэн ажлууд.....	9
3.4. Нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ...	10
3.5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	13
3.6. Түүх соёл, шинжлэх ухааны дурсгалт зүйлс	13
Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	14
3.7. 14	
3.8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	15
ДҮГНЭЛТ	20

Зураг

Зураг 1. Талбайн байршлын тойм зураг	3
Зураг 2. Талбайд үерийн далан байгуулсан байдал.....	9
Зураг 3. Хөрс бохирдох болон галын аюулаас сэргийлэн саармагжуулах элс	10
Зураг 4. Шимт хөрсийг хамгаалж стандартын дагуу хадгалсан байдал	11
Зураг 5. Дүйцүүлэн хамгаалах ажлаар техникийн нөхөн сэргээлт хийж байх үед	12
Зураг 6. Дүйцүүлэх хамгаалах хийсэн талбай	12
Зураг 6. Хог хаягдлын цаг байгуулан ажилласан	13
Зураг 7. Уурхайд сургалт явуулж буй байдал.....	15

Хүснэгт

Хүснэгт 1. Талбайн солбицол	2
Хүснэгт 2. 2023 онд явуулах уулын ажлын хэмжээ	5

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн товч танилцуулга

Манай компани нь жил бүр байгаль орчны менежментийн төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж холбогдох албан тушаалтан, баталж хариуцсан мэргэжилтнүүд баталгаажуулсан.

“Хэрлэн энерго” ХХК нь Дундговь аймгийн Луус, Өлзийт сумдын нутагт Тал нэртэй хайлуур жоншны орд бүхий 242.74 га талбайтай MV-020942 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг. 2022 онд Талын жоншны уурхай нь 20 мян.тн хүдэр олборлон үүнээс ФК75 маркийн бүхэллэг жонш 2 мян.тн, ФР маркийн 18 мян.тн 51.7%-н агуулгатай жоншны хүдрийн бүтээгдэхүүн гаргах төлөвлөгөөтэй байна. 2 мян.тн ФК75 маркийн бүхэллэг жоншийг БНХАУ-лс руу экспортолж, ФР маркийн 18 мян.тн 51.7%-н агуулгатай жоншны хүдрийг дотооддоо баяжуулах үйлдвэрт гэрээгээр нийлүүлэхээр төлөвлөж байна. ТЭЗҮ-гээр ангилан ялгах төхөөрөмж хэрэглэх тооцоо хийгдсэн боловч санхүүгийн хүндрэл болон COVID19-тэй холбоотойгоор мөн санхүүгийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан өнөөдрийг хүртэл олборлолтын ажил явуулаагүй.

1.1. Төслийн товч тодорхойлолт


“Тал” талбай нь засаг захиргааны нэгжийн хувьд Дундговь аймгийн Луус, Өлзийт сумдын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос урагш 335 км, Мандалговь хотоос урагш 60 км зайд тус тус байрлана.

- Талбайн нэр: “Тал”
- Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн дугаар: MV-020942
- Ашиглалтын талбайн хэмжээ: 242.74 га

Хүснэгт 1. Талбайн солбицол

Булангийн цэгийн дугаар	Газарзүйн солбицол, град WGS-84	
	Өргөрөг	Уртраг
1	45° 18' 26.36"	106° 05' 02.44"
2	45° 17' 31.53"	106° 05' 02.44"
3	45° 17' 31.53"	106° 03' 56.58"
4	45° 18' 26.36"	106° 03' 56.58"

Уурхай нь бүрэн хүчин чадалдаа хүрэхээс өмнө газрын дээрх, доорх барилга байгууламжийн ажил, ил уурхай, газрын гүндэх үндсэн малталтуудыг нэвтрэх, тэдгээрийг бүрэн тоноглож бэхлэх, нээх бэлтгэл малталтуудыг нэвтрэх, түүнээсээ олборлолтод бэлтгэх малталтуудыг нэвтэрч хүдрийг олборлолтод бэлтгэх хүдэр нураалтын ажлууд хийгдсэний дараа уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллах ба ашиглалтын хоёр дахь жилээс эхлэн 20.0 мян.тн CaF₂ 54.2%-ийн дундаж агуулгатай хайлуур жонш олборлох бөгөөд уурхай нь нийтдээ 10 жил ажиллахаар төлөвлөсөн болно.





Зураг 2. Уурхайн ерөнхий байдал

1.2. 2023 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ХЭМЖЭЭ, АЖИЛЛАХ ГОРИМ

Тус орд нь 2022 онд ажиллаагүй бөгөөд 2023 онд ил аргаар ашиглана. Ингэхдээ 60.84%-ын хүдрийн дундаж агуулгатай 179652.9 тн геологийн хүдрийн нөөц олборлоно. 1-р хүдрийн биетийн бодит В нөөцийн хүрээнд судлын зузаан нь газрын гадаргуугаас 5-6м-ийн гүнд өргөн байгаа учир энэ хэсэгт ил уурхайн аргаар олборлолтыг явуулах боломжтой учир уурхайг эхлэх ажлын явцад тус биетийн үйлдвэрлэлийн нөөцийн 6.1 мян.тн-г ил уурхайн аргаар, үлдсэн 186.57 мян.тн-г далд уурхайн аргаар олборлох сонголтыг ТЭЗҮ-д тусгаж холбогдох тооцооллыг хийв.

Жилд ажиллах хоногийн тоо 330 байна. Уулын ажлыг газрын дор ажиллах далд уурхайн хэсэгт 7 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр, газрын дээр ажиллах хэсэгт 8 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр сонголоо.

Хүснэгт 2. 2023 онд явуулах уулын ажлын хэмжээ

№	Түвшин	Хөрс м3	Хүдэр м3	Уулын цул м3
1	Ил уурхай	135031	66977	202008

1.3. Үйлдвэрлэлийн нөөц

Үйлдвэрлэлийн нөөцийг тооцохдоо ашиглалтын блок бүрээр тус бүрд нь тодорхойлж бэлтгэл ажил, огтолгооны ажил мөн цэвэрлэгээний ажлаар олборлох хүдрийн бохирдлыг үндсэн хүдрийн биетийн хувьд тооцооллоо.

1.4. Хүдрийн хаягдал, бохирдол

“Тал” нэртэй хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглахад, 60.84%-ын хүдрийн дундаж агуулгатай 179652.9 тн геологийн хүдрийн нөөц ашиглахаар тооцов. Үүнээс үйлдвэрлэлийн нөөцийн тооцоог тодорхойлохдоо хүдрийн биетийн геологийн тогтоц, уул техникийн нөхцөл, хүдрийн биетийн шинж чанар, тус ордыг ашиглах ашиглалтын систем зэргээс хамааруулан тооцоолов. Хүдрийн хаягдал, бохирдолтыг үнэн зөв тооцож байх нь уурхайн технологийн үйл ажиллагаанд хяналт шалгалт тавих, материаллаг урамшууллын хөшүүрэг болгон ашиглах, хаягдал бохирдолтыг багасгах арга хэмжээг авч явуулах нөхцөлийг олгоно. Хүдрийн хаягдал, бохирдлыг тодорхойлох аргыг шууд ба шууд биш гэж ангилдаг. Хүдрийн хаягдал, бохирдлыг тодорхойлох шууд арга нь хаягдсан ба бохирдсон хүдрийг шууд байгаа байдлаар нь хэмжиж тодорхойлдог бөгөөд хоршоолон нураах ашиглалтын системийн үед нэлээд бодитой үр дүн гаргах бололцоотой юм. Хүдэр хоршоолох ашиглалтын системийн хувьд хаягдал харьцангуй бага байдгаараа давуу талтай юм. Хамгийн гол хаягдал нь блок хооронд үлдэх хамгаалалтын цул ба ул таазанд үлдэх хамгаалалтын цулууд болно. Хүдрийн бохирдлын төрлүүд: Хүдрийн бохирдол нь зөвхөн ашиглалтын үед гардгаараа хаягдлаас ялгаатай бөгөөд дараах үндсэн төрлүүдэд хуваагдана. Олборлолтын явцад хүдэр чулуулагтай холилдоноос үүссэн бохирдол:

Энэ нь хүдрийг өрөмдлөг тэсэлгээний аргаар нураах үед практикт хүдэр ба хоосон чулуулгийг зааглан нураах боломж байхгүйгээс олборлолтын ил орон зайд хана ба таазны чулуулаг нурснаас, хүдэртэй хамт хоосон чулуулгийн хэсэг хамт ачигддаг, нарийн судлыг /0.6-0.8м зузаантай/ олборлох үед олборлолтын орон зай өргөссөнөөс үүснэ.

2023 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ХЭМЖЭЭ, АЖИЛЛАХ ГОРИМ

Уурхай нь 2023 онд 1 сарын хугацаатай ажилласан.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Зам харилцаа ба дэд бүтэц: Төслийн талбай нь Дундговь аймгийн Мандалговь хотоос 60 км, УБ хотоос зүүн урагш 335км, засаг захиргааны мужлалаар Дундговь аймгийн Өлзийт, Луус сумдын нутагт оршино. Луус сумын төвөөс зүүн урагш 33 км зайд байрлана.

Монгол Улсын босоо тэнхлэгийн Улаанбаатар-Өмнө-говийн АО201-р код бүхий асфальтан замаар Улаанбаатар хотоос Мандалговь хот хүртэл 335 км явж түүнээс цааш 60 км шороон замаар явж төслийн талбайд хүрнэ. Орон нутгийн шинж чанартай замаар тухайн талбайд аль ч талаас нь жилийн 4 улиралд хүрэх бүрэн боломжтой. Замын нөхцөл сайн гэж хэлж болно.

Тал хайлуур жоншны ордод 35 кВт-ын өндөр хүчдэлийн шугам талбайгаас баруун тийш 10 км зайтай дайран өнгөрдөг.

Газар зүй: Физик газарзүйн мужлалаар Төв Монголын тал хээрийн бүс, Өмнөт Монголын говь хээрийн бүсийн заагт оршдог. Энэ бүс нутаг голдуу тал газар, намхан жижиг толгодоос бүрдэнэ. Ажлын талбай нь газарзүйн хувьд далайн түвшингээс дээш 1100-1200 м өндөрт оршино. Баруун хойноос зүүн урагш чиглэлтэй янз бүрийн жижиг хөндийнүүд, ам жалгуудаар хэрчигдсэн рельефтэй. Тал хайлуур жоншны орд нь 1150 м байрлана. Талбайг хүрээлсэн жижиг уул толгодуудаас эргэн тойрон дахь орчныг 5-10 км хүртэл зайд харах боломжтой. Талбайн зүүн хойд хэсэг илүү толгодорхог гадаргуутай ба 25-40 м хооронд өндөршил нь хэлбэлздэг байна. Талбайн гадаргууд чулуулгийн илрэх гарш нь гүвээ толгодын оройгоор дэл судал хэлбэртэй оршино.

Ус зүй: Талбайд гадаргуугийн усан сүлжээ харьцангуй муу хөгжсөн. Төслийн талбайн эргэн тойронд Дунд жирийн худаг, Гашууны худаг, Зэстийн худаг, өрөмдмөл худгууд, 2-10км зайд байршдаг. Худгуудын усны ундарга ихэвчлэн 0.1-0.8 л/с хэлбэлзэх бөгөөд газрын гүнээс тэжээгдэнэ. Хүнсний зориулалттай усны хэмжээ энэ нутагт нэлээд хүндрэлтэй юм. Учир нь нэлээд олон тооны худгууд байдаг боловч усны шинжилгээгээр тэр болгон ундны усны шаардлага хангадаггүй.

Ургамал: Хөрсний бүтэц нь тархалтын байдлаараа талбайн хэмжээнд харьцангуй жигд тархалттай. Ургамлын хөрсний үеийн зузаан 0.05-0.2 м хааяа 0.4 м хүрдэг. Тал хөндий, энгэр бэл газраар таана, хөмүүл, агь зэрэг говийн шимт ургамлаас гадна шарилж зангуу, толгодын орой, хажуу бэлээр хялгана, хазаар өвс ургана. Говирхог хэсгээрээ нохойн шийр, алтан харгана, дэрс, буйлс, бударгана зэрэг бутлаг ургамал ургадаг.

Ан амьтан: Төслийн талбайн орчимд ан амьтад нэлээд элбэг бөгөөд ихээхэн хэмжээгээр тохиолдох амьтдаас цагаан зээр орно. Түүнчлэн бусад өвсөн тэжээлтэн, мэрэгчид, шавж, хэвлээр явагчид, жигүүртэн шувуудаас гадна махчин амьтад тохиолдох нь элбэг. Махчин амьтдад үнэг, хярс, мануул, дорго, зараа, ховроор чоно байдаг бол өвсөн тэжээлтнээс цөөн тоогоор хар сүүлт, зарим хэсгээр тарвага бий. Дулааны улиралд тогоруу, ангир зэрэг шувууд нүүдэллэн ирдгээс гадна нутгийн хэмжээнд байнга амьдардаг шувуудаас элээ, хэрээ, тас, сар, бүргэд, ногтруу, тагтаа, чогчиго, болжмор, харцага, зэргийг нэрлэж болно.

2.1. 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, биелэлт

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу боловсруулан батлуулсан.

Ордын хувьд 2023 онд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийхгүй.

Дүйцүүлэн хамгаалах ажлаар орон нутгаас зааж өгсөн 1 га талбайд Луус сумын төвд техникийн нөхөн сэргээлт хийсэн.

Ус ашиглах, болон хог хаягдлын гэрээг орон нутгийн байгууллагуудтай хийн, гэрээний дагуу ажилласан.

“Тэр бум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд орон нутгаас заасан талбайд төлөвлөсний дагуу 100 ш мод тарьсан.

2023 оны орчны хяналт шинжилгээний ажлыг Байгаль орчны үнэлгээ зөвлөгөөний “Ногоон эко мандала” ХХК-тай гэрээ хийн 8-р сард хийлгэсэн бөгөөд тус ажлын хүрээнд агаар, ус, хөрснөөс дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийлгэн, ургамлын судалга хийлгэсэн.

Бид 2023 оны БОМТ-д заардсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажилссан.

3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

3.1. Агаар орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажил:

Үйл ажиллагаа явагдахаас өөр газруудад машин, техникүүдийг замбараагүй явуулахгүй байх зааварчилгааг тогтмол өгч мөрдүүлж ажилласан ба 2023 оны БОМТ-д тусгагдсан дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Хүснэгт 3. Агаар орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажил

Д/д	Төлөвлөгөө	Хариуцсан эзэн	Биелэлт, зарцуулсан зардал мян.төг
1	Уурхайн дотоод замыг услах,	Уурхайн дарга	Уурхайн нь зуны 1 сар ажилласан. Тэр үед усалгаа хийгээгүй.
2	Уурхайд ажиллаж байгаа машин техникийн кабин доторх агааржуулах төхөөрөмж, хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хаалга, цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг тогтмол хийж, зөрчил илэрсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч бүхээгт тоос орохгүй болгох арга хэмжээ авч байх		250 мот/цаг тутамд тээврийн хэрэгслүүдийн масло, маслын шүүр, агаар болон, түлшний шүүрүүдийг байнга сольж байсан. Үйл ажиллагааны зардалд орсон.
3	Мөн агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлнэ.		Хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан агаарын шинжилгээг 8-р сард хийлгэсэн.
4	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлнө. Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.		Агаарын бохирдлын төлбөр төлсөн
	Нийт		200.0 мян төг

3.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажил

Ус, усан орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах:

Ус ашиглах гэрээг 2023 оны 09 сард Дундговь аймгийн Өлзийт сумын засаг даргатай гэрээ байгуулсан.

Хүснэгт 4. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалахад хийгдсэн ажлууд

Д/д	Төлөвлөгөө	Хариуцсан эзэн	Биелэлт, зарцуулсан зардал мян.төг
1	Ус ашиглах гэрээгээ байгуулан төлбөрөө төлнө	Компанийн захирал	Ус ашиглах гэрээг байгуулан 50.0 мян төгрөгийн төлбөр төлсөн. Гэрээг хавсаргав
2	Уурхайгаа тойруулан үерийн далан байгуулах	Уурхайн дарга	Уурхайгаа тойруулан үерийн далан байгуулсан. Зардал нь үйл ажиллагааны зардалд орсон
3	Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх		Хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан агаарын шинжилгээг 8-р сард хийлгэсэн.
	Нийт зардал		50.0 мян.төг



Зураг 3. Талбайд үерийн далан байгуулсан байдал

3.3. Хөрс, ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалахад хийгдсэн ажлууд

Хүснэгт 5. Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажлууд

Д/д	Төлөвлөгөө	Хариуцсан эзэн	Биелэлт, зарцуулсан зардал мян.төг
1	Газар эзэмших гэрээгээ сумын засаг даргатай байгуулах, төлбөрөө төлөх	Компанийн захирал	Хүсэлтээ өгсөн бөгөөд Иргэдийн хурлаар батлагдсан бөгөөд Засаг даргын захирамж хүлээгдэж байна.
2	Засварын газраас өөр газарт тос масло асгарсан тохиолдолд асгарсан хэсгийг элс асгаж саармагжуулан бохирдсон хөрсийг авч хог хаягдал руу ачуулна.	Уурхайн дарга	Хөрс бохирдохоос сэргийлэн саармагжуулах элс бэлдэж тавьсан. Зардал нь үйл ажиллагааны зардалд орсон.
3	Хог хаях, шатах тослох материал асгах, хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлэх, олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах		Хог хаягдал, шатах тослох материалын асгаралт дээр авах арга хэмжээний талаар сургалт явуулсан. Зардал нь үйл ажиллагааны зардалд орсон.
	Нийт зардал		- мян.төг

Зураг 4. Хөрс бохирдох болон галын аюулаас сэргийлэн саармагжуулах элс



Хүснэгт 6. Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалахад хийгдсэн ажлууд

Д.д	Төлөвлөгөө	Хариуцсан эзэн	Биелэлт, зарцуулсан зардал мян.төг
1	Олон салаа зам гаргахгүй байх	Уурхайн дарга	Тусгай зөвшөөрлийн талбай болон орон нутагт тогтсон маршрутаар зорчсон бөгөөд гарц таних тэмдэг байршуулсан.
2	Гал түймрийн аюулаас хамгаалж гал унтраах багаж хэрэгслийг хотхонд байршуулсан.	Уурхайн дарга	Зураг 1
3	Орд орчмын ургамлын бүрхэц, зүйлийн бүрдлийн судалгаа	Компанийн захирал	Орд орчмын хяналт шинжилгээний ажлыг 8-р сард хийж гүйцэтгэсэн бөгөөд зардал нь хяналт шинжилгээ, мониторингийн зардалд орсон.
	Нийт		100.0

3.4. Нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

2023 онд уурхайн техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийхгүй.

Д.д	Төлөвлөгөө	Хариуцсан эзэн	Биелэлт, зарцуулсан зардал мян.төг
1	Шимт хөрс хадгалах хамгаалах		Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдсэн ажлуудад тусгагдсан.

2	Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд сумаас зааж өгсөн талбайн техникийн нөхөн сэргээлт хийсэн.		3500.0 мян.төгрөг зарцуулсан.
	Нийт зардал		3500.0 мян.төг



Зураг 5. Шимт хөрсийг хамгаалж стандартын дагуу хадгалсан байдал



Зураг 6. Дүйцүүлэн хамгаалах ажлаар техникийн нөхөн сэргээлт хийж байх үед Хүснэгт 8. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Д.д	Төлөвлөгөө	Хариуцсан эзэн	Биелэлт, зарцуулсан зардал мян.төг
1	“Тэр бум мод” Үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2023 онд орон нутгаас зааж өгсөн талбайд 100 ш мод сөөг тарималжуулахаар төлөвлөв.		100 ш мод орон нутгаас заасан талбайд тарималжуулав Зардал нь 1500.0 мян.төг

Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд хийсэн нөхөн сэргээлтийн талбай



Зураг 7. Дүйцүүлэх хамгаалах хийсэн талбай

3.5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 9. Хог хаягдлыг менежментээр хийгдсэн ажлууд

Д.д	Төлөвлөгөө	Хариуцсан эзэн	Биелэлт, зарцуулсан зардал мян.төг
1	Ахуйн хог хаягдлаа эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан зайлуулах.	Компанийн захирал	2023 онд байгуулсан гэрээ байгуулан 300.0 мян төгрөгийн төлбөрөө төлсөн. Заасан газраас өөр газар хог хаяагүй. Хог хаягдлаа ангилан ялгаж байсан. Өөрийн эзэмшил талбайн эргэн тойронд 50 м газрыг тогтмол цэвэрлэж байсан. Хотхоны зам талбай, уурхайлалтын хэсэгт гэрэлтүүлэг нэмсэн. Дотоод зардалд орсон
2	Хог хаягдлын төлбөрөө төлөх.		
3	Ахуйн хаягдлыг хаях цэг байгуулах.		
4	Хог хаягдлын гэрээнд заасны дагуу эзэмшил газрын ойролцоо талбайг цэвэрлэх		
5	Орчин тойрондоо гэрэлтүүлэг хийсэн.		
Нийт зардал			300.0 мян.төгрөг



Зураг 8. Хог хаягдлын цаг байгуулан ажилласан

3.6. Түүх соёл, шинжлэх ухааны дурсгалт зүйлс

Ордын ашиглалтын талбай түүний ойр орчимд түүх соёл, шинжлэх ухааны дурсгалт зүйлс байхгүй болно.

3.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	2023 оны БОМТөлөвлөгөө			2023 оны БОМТөлөвлөгөөний биелэлт
	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт
1	Аянга буух	Аянга, цахилгаантай ширүүн бороотой, хүчтэй салхи шуургатай үед гадаах ажлыг түр зогсоох	Уурхайн эдэлбэр газарт	Цаг агаарын урьдчилан сэргийлэх болон онц аюултай үзэгдлээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, мэдээ, дохиог хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн бусад эх сурвалжаас тогтмол хүлээн авч дуу цахилгаантай ширүүн бороотой, хүчтэй салхи шуургатай өдөр ил уурхайн ажлыг түр зогсоов.
2	Гал түймэр	Төслийн талбай болон уурхайн хотхонд байршуулсан гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн бүрдлийг тогтмол шалгах. Бүх машин механизмд галын хор байршуулах. Гал түймрээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах тэмдэг, тэмдэглэгээ мэдээлэх самбар зэргийг байршуулах.	Ашиглалтын талбай болон уурхайн хотхон	Уурхайн талбайд гал түймэр, онцгой байдалд эрсдэлийг бууруулах чиглэлээр ажлын талбайд тогтмол ажлын байрны үзлэгүүд зохион байгуулж, гал түймэр гарч болзошгүй бүх цэгүүдэд гал сараа, унтраах, хэрэгслүүдийг бүрэн суурилуулсан. Гал түймэртэй тэмцэх болон Гамшгийн тухай хуулийн дагуу уурхайн талбайн барилга эрсдэлийн үнэлгээний дагуу, бүх хэсэг нэгжүүдэд онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөөг Уул уурхайн аврах ангиар батлуулан мөрдөн ажиллаж байна.
3	Хүний эрүүл мэнд муудах	Хүний эрүүл мэнд муудахад тухайн нөхцөлд хамгийн тохиромжтой газар руу нүүлгэн шилжүүлэхийг ажлыг зохион байгуулна.	Уурхайн талбайд	Уурхайн нийт ажилчдын эрүүл мэндэд хяналт тавих шаардлагатай тохиолдолд эмлэлгийн тусламж үзүүлэх зорилгоор сумын эмнэлэгт үзлэг хийлгэж байна.
4	Автомашин осол	Тээврийн хэрэгслийн жолоочид Замын хөдөлгөөний аюулгүйн дүрэм болон компанийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч сургалтыг зохион байгуулах.	Уурхайн талбай болон хүдэр тээврийн зам	МУ-ын холбогдох хууль тогтоомж, Замын хөдөлгөөний аюулгүй ажиллагааны дүрэм болон уурхайн аюулгүй ажиллагааны зааварчилгааны хүрээнд холбогдох аюулгүй ажиллагааны журмыг боловсруулан тогтмол мөрдөн ажиллаж байна.

3.8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулсан. Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга хариуцан ажилласан.



Зураг 9. Уурхайд сургалт явуулж буй байдал

Хүснэгт 10. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлсэн удирдлага зохион байгуулалтын ажил

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хариуцсан эзэн	Тайлбар, зарцуулсан зардалан мян.төг
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөж ажилласан.	Уурхайн дарга	Дотоод төлөвлөгөөг
2	Газрын төлөв байдлын хянан баталгааг 2023 онд “Эко хайран” ХХК буюу Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ газрын мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн. Байгаль орчны аудитыг хийлгэх хуулийн хугацаа болоогүй тул 2023 онд хийлгээгүй 2024-2025 онд хийлгэхээр төлөвлөж байна.		

3.9. Хяналт шинжилгээний ажлын биелэлт

№	Хяналт шинжилгээний дээж	Хяналт шинжилгээний үзүүлэлт	Хяналт шинжилгээ явуулсан хугацаа	Хяналт шинжилгээ явуулсан байршил	Хяналт шинжилгээ хийсэн багаж, холбогдох стандарт
1	Агаар	Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж,	8 сард	Уурхайн хотхон Засварын талбай, Уурхайн карьер, Уурхайн зам	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын чанар- хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 2010, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2007 Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 Агаарын тоосжилтыг Dusttrak 8530 Шинжилгээний аргын стандарт, MNS 17.2.5.12:88 MNS 17.2.5.11:88
2	Ус	Усны ерөнхий химийн шинжилгээ, бактериологийн шинжилгээ (рН, ЕС, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, рН, цахилгаан дамжуулах чанар, Cl, SO ₄ , NO ₂ , NO ₃ , CO ₃ , HCO ₃)	8 сард	Гүний худаг	Усны тухай хууль, Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2008, Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2005, Бохир ус 4943:2015,
3	Хөрс	Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөнт фосфор, солилцох кали, карбонат, Хүнд металл (Cr, Pb, Cd, Ni, Zn), бактери	8 сард	Засварын талбай Шимт хөрсний овоолго, кемп	- MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл - MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох - MNS2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам - MNS(ISO)4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх

2023 оны Орчны Хяналт Шинжилгээний ажлыг тус оны 8-р сард Байгаль орчны үнэлгээ, зөвлөгөөний “Ногоон Эко Мандала” ХХК хийж гүйцэтгэсэн.

Тус орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу ус, хөрс, агаарын шинжилгээг хийлгэсэн.

Агаар:

Агаарын чанарын хэмжилт нь агаарын чанарын стандарт MNS 4585:2016-аас тоосны агууламж болон азот, хүхэрлэг хийн агууламжаар хэтэрсэн үзүүлэлт байхгүй.

Ургамал:

Цөлийн хээрийн үндсэн бүлгэмдэл болох баглуур-улаан бударганат бүлгэмдэлтэй. Гуу жалгаараа хармагт, бударганат зэрэг хагас сөөглөг ургамалын ургамалжилтай.

БОНХАЖЯ-ны 2015 оны 282 дугаар сайдын тушаалаар батлагдсан Ашигт ургамлын жагсаалтад ховор тархалтай 1 зүйл (*Zygophyllum potaninii*- потанини улаан тулам), элбэг тархалттай 7 зүйл (*Allium polyrrhizum*-таана, *Convolvulus ammonii*-Аммоний сэдэргэнэ, *Peganum nigellastrum*- өмхий өвс, *Rheum nanum*- намхан бажууна) ургамал ургана.

Бэлчээрийн талхагдал бага.

Хөрс:

Хөрсөн дээр хүнд металл илрээгүй. Цаашид засварын талбайг цементлэхийг зөвлөсөн. Бактериологийн шинжилгээгээр эмгэг төрөгч зүйл илрээгүй.

Ус:

Ундны усны химийн шинжилгээг “Инженер геодези” ХХК-ын Усны лабораторид шилжүүлсэн. Ундны усны шинжилгээг тус талбайд ойролцоо байдаг малчны гар худгаас ундны усаа зөөврөөр хангадаг. Тус худгийн уснаас химийн шинжилгээ хийлгэсэн. Энэ худгийн ус нь химийн бүрэлдэхүүнээрээ хлорын ангийн, натрийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү буюу харьцангуй ихэвтэр эрдэсжилттэй, хатуу ус байна.





Зураг 10. Уурхайн Орчны хяналт шинжилгээ хийж байх үед /2023.08.06/

Хүснэгт 11. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Д. д	Зардлын утга	Нийт зардал, мян.төг
1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	200.0
2	Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	-
3	Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	100.0
4	Хог хаягдлын менежментээр хийгдсэн ажлын зардал	300.0
5	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	50.0
6	Нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах, мод тарималжуулах ажилд	5000.0
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	5000.0
8	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	Дотоод зардал
	2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн	10650.0

ДУГНЭЛТ

“Хэрлэн энерго” ХХК нь Дундговь аймгийн Луус, Өлзийт сумдын нутагт Тал нэртэй хайлуур жоншны орд бүхий 242.74 га талбайтай MV-020942 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг. Тус талбай нь засаг захиргааны нэгжийн хувьд Дундговь аймгийн Луус, Өлзийт сумын нутагт байрладаг.

Уурхайн ус ашиглах гэрээг уурхайн хотхон байрладаг Өлзийт сумын Засаг даргатай 2023 оны 09-р сард байгуулсан.

Техникийн болон Биологийн нөхөн сэргээлт 2023 онд төлөвлөөгүй.

Ордын хувьд 2023 онд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийхгүй. Дүйцүүлэн хамгаалах ажлаар орон нутгаас зааж өгсөн 1 га талбайд Луус сумын төвд техникийн нөхөн сэргээлт хийсэн.

Ус ашиглах, болон хог хаягдлын гэрээг орон нутгийн байгууллагуудтай хийн, гэрээний ажилласан.

“Тэр бум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд орон нутгаас заасан талбайд төлөвлөсний дагуу 100 ш мод тарьсан.


2023 оны орчны хяналт шинжилгээний ажлыг Байгаль орчны үнэлгээ зөвлөгөөний “Ногоон эко мандала” ХХК-тай гэрээ хийн 8-р сард хийлгэсэн бөгөөд тус ажлын хүрээнд агаар, ус, хөрснөөс дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийлгэн, ургамлын судалга хийлгэсэн.

2023 оны 11-р сарын байдлаар нийт 2023 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 10.6 сая төгрөг зарцуулсан байна.

Хавсралт 1. Усны төлбөр төлсөн баримт

		Огноо/Date: 2023.10.30 14:19:01		
Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information				
Журналын/Journal No: 23743215				
Системийн огноо/System Date: 2023.10.30 14:19:01				
Дт/From	IBAN/Дансны/ Картын дугаар IBAN/Account/Car d number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5447050311	ХЭРЛЭН ЭНЕРГО ХХК	50,000.00 MNT	1.00
/ Тавин мянган төгрөг /				
Кт/To	Банкны дугаар/Branch No - IBAN/Дансны/ Картын дугаар IBAN/Account/Car d Number	Банкны нэр/Bank Name Khаn Bank - Хаан банк Нэр/Name МТА.ТАТВАР	50,000.00 MNT	1.00
Гүйлгээний утга/Transaction description: 2231005237879; 2871114; 88000012				

Хавсралт 2. Хогны төлбөр төлсөн баримт

		Огноо/Date: 2023.10.30 14:20:17		
Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information				
Журналын/Journal No: 23830679				
Системийн огноо/System Date: 2023.10.30 14:20:17				
Дт/From	IBAN/Дансны/ Картын дугаар IBAN/Account/Car d number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5447050311	ХЭРЛЭН ЭНЕРГО ХХК	300,000.00 MNT	1.00
/ Гурван зуун мянган төгрөг /				
Кт/To	Банкны дугаар/Branch No	Банкны нэр/Bank Name		
	-	Khаn Bank - Хаан банк	300,000.00 MNT	1.00
	IBAN/Дансны/ Картын дугаар IBAN/Account/Car d Number	Нэр/Name		
	5176120446	МТА.ТАТВАР		
Гүйлгээний утга/Transaction description: 2231005238018; 2871114; 88000012				